ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/009/НА-СТА-ТЕЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбуунprinc<br>Утас:329871 Цахим хаяг:Sambuunyamya@audit.gov.mn<br>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цогбаяр<br>Утас: 51-260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Бүжинханд<br>Утас:51-261628 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2025.04.25 № 1595

танай ____________-ны № ____________-т

МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД С.АМАРСАЙХАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын /онцгой байдлын асуудал эрхэлсэн/ эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 141,347.6 сая төгрөгийн зөрчил бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, санхүүгийн тайлагналын “ангилал”, “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

1. Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний 77 байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлантай холбоотой нийт 104,204.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой;
2. Харьяа байгууллагууд тайлант онд хугацаа хэтэрсэн 13,154.7 сая төгрөгийн авлага, 7,255.3 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарч төсвийг зохистой удирдаж чадаагүй;
3. Зарим харьяа байгууллагууд өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгаагүй, 2,502.3 сая төгрөгийн, орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж зарцуулсан, урсгал зардлын санхүүжилтээс нийт 208.0 сая төгрөгөөр эдийн ангилал зөрчиж үндсэн хөрөнгө бэлтгэсэн;

Z:\Yawsan_Bichig\2025\0425 SNAG-17.Docx

1525040520

4. Өмнөх оны аудитаар өгсөн 278.2 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 44 дүгээр зүйлийн 44.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын нөөц сангаас 44,764.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 22,223.8 сая төгрөг, Засаг даргын нөөц сангаас 8,046.1 сая төгрөг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 6,680.3 сая төгрөгийн хандив тусламж, дээд шатны төсвийн захирагчаас 6,030.9 сая төгрөг, нийт 87,745.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 81,278.3 сая төгрөгийн зарцуулан, 6,467.3 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дагуу Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 224 дүгээр тушаалаар 2024 оны жилийн эцэст Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос нийт 6,014.7 сая төгрөгийг зарцуулах эрхийг олгосныг журмын дагуу зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 12 төсөл, арга, хэмжээний санхүүжилтэд нийт 89,687.7 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 99.5 хувь буюу 89,205.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор “Малчдад тусалъя” хандивын аянд 52 иргэн, 33 аж ахуйн нэгж, 119 төрийн байгууллага, 32 төрийн бус байгууллага зэргээс нэмэлт санхүүжилтийн дансанд 19.1 сая төгрөг, ХААН банкны дансанд 3,870.2 сая төгрөг, нийт 3,882.5 сая төгрөгийн мөнгөн хандив хүлээн авснаас Монгол Улсын Шадар Сайдын 2024 оны 25, 42, 43, 51, 114, Улсын Онцгой комиссын даргын 2024 оны 4, 5, 8, 11, 12 дугаар тушаалын дагуу өвөлжилт хаваржилт хүндэрсэн аймаг, сумдад дэмжлэг үзүүлэх, хаагдсан зам давааг нээх, зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгахад ажилласан алба хаагчдын томилолт, ариутгал халдваргүйтгэлийн төлбөр болон үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор зөөврийн далан, хүн нэг бүрийн усны хувцас, цув, бээлий зэргийг худалдан авахад нийт 3,657.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

**Бусад асуудал**

Онцгой байдлын байгууллагууд нь Гамшгаас хамгаалах хууль, тогтоомж, түүнтэй холбоотой төрийн бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ.

Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэх, бохирдлыг бууруулах, живсэн тээврийн хэрэгслийг илрүүлэх, байршлыг тогтоох, татан гаргах ажлыг 2021-2024 онуудад Онцгой байдлын ерөнхий газраас удирдан зохион байгуулж Зэвсэгт хүчний жанжин штаб, Шинжлэх ухаан, техникийн их сургууль, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн эрдэмтэд, зөвлөх инженер, судалгааны баг хамтран Хөвсгөл нуурт живсэн "Сүхбаатар" хөлөг онгоц болон бусад 11 автомашин, техник хэрэгслийг 33.4-171 метрийн гүнээс татан гаргаж, тэдгээрт агуулагдаж байсан 50 орчим тонн шатахуун, тос тосолгооны материал, аюултай хог хаягдлыг аюулгүй болгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон "Хурдтай хөгжлийн төлөөх зориг" хамтарсан Засгийн газрын гэрээнд "Бүсчилсэн хөгжлийн бодлого"-ыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Засгийн газраас 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарлаж энэ хүрээнд 23 жилийн дараа баримтлал"-ыг Улсын Их хурлаар хэлэлцэн баталжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн 33 дугаар тогтоолоор "Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн" УТҮГ нь Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд үүсгэн байгуулагдсан. Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 59 тоот тушаалаар тус хүрээлэнгийн бүтэц, орон тоо батлагдсанаар үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2025\0425 SNAG-17.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

| **Тайлангийн үзүүлэлт** | **Тодруулга** | **2023оны 12-р сарын 31** | **2024 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **195,524,414.0** | **358,079,688.8** |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 531,263.8 | 60,873,236.8 |
| АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 20,907,181.7 | 18,605,011.8 |
| УРЬДЧИЛГАА | 7а, 7б | 1,816,397.7 | 4,123,620.9 |
| БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 83,663,764.6 | 81,872,194.2 |
| НӨӨЦИЙН БАРАА | 9а | 79,530,958.9 | 90,086,127.6 |
| БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 10 | 9,074,847.3 | 102,519,497.5 |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **373,808,509.3** | **431,825,626.1** |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 373,808,509.3 | 431,825,626.1 |
| Биет хөрөнгө | | 338,120,283.4 | 391,478,025.2 |
| Биет бус хөрөнгө | 13 | 35,688,225.9 | 40,347,600.9 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **569,332,923.3** | **789,905,314.9** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **5,189,716.4** | **67,727,954.4** |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15а, 15б | 5,189,716.4 | 67,727,954.4 |
| Богино хугацаат зээлийн өглөг | 16а, 16б | 103,702.8 | - |
| Өглөг | 17а, 17б | 5,083,863.6 | 67,723,082.4 |
| Урьдчилж орсон орлого | 18а, 18б | 2,150.0 | 4,872.0 |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **564,143,206.9** | **722,177,360.5** |
| Засгийн газрын хувь оролцоо | | 564,143,206.9 | 722,177,360.5 |
| Засгийн газрын оруулсан капитал | | 106,643,256.2 | 114,420,218.7 |
| Хуримтлагдсан үр дүн | | 407,278,690.4 | 557,132,504.5 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 50,221,260.3 | 50,624,637.3 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **569,332,923.3** | **789,905,314.9** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

| Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | **290,470,100.2** | **554,801,318.8** |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 72,341,270.9 | 136,999,534.7 |
| Нийтлэг татварын бус орлого | | 72,341,270.9 | 132,819,201.5 |
| Тусламжийн орлого | | - | 4,180,333.2 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 218,128,829.3 | 417,801,784.2 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2а, 2б** | **234,411,407.6** | **361,643,916.0** |
| УРСГАЛ ЗАРДАЛ | | 234,411,407.6 | 360,446,186.2 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 211,307,886.9 | 337,671,297.4 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 108,932,819.2 | 161,387,582.2 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 4,581,922.4 | 6,462,016.4 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 8,354,954.1 | 9,254,545.5 |
| Хангамж, бараа материалын зардал | | 7,818,874.8 | 12,939,553.1 |
| Норматив зардал | | 10,138,265.0 | 11,347,970.8 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | | 6,353,920.3 | 6,800,153.6 |
| Томилолт, зочны зардал | | 1,460,363.7 | 2,630,835.2 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 18,951,071.2 | 25,132,099.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 44,715,696.3 | 101,716,541.1 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 23,103,520.8 | 22,774,888.8 |

| | | | |
|---|---|---|---|
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | - | 1,197,729.8 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | **56,058,692.6** | **193,157,402.9** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | | **42,496.4** | **1,818,328.8** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **51,407,509.0** | **38,111,589.1** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | | **4,693,679.9** | **156,864,142.5** |

## 2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **244,892,297.4** | **514,521,984.8** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 17,810,276.8 | 85,461,784.2 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 17,810,276.8 | 82,243,884.7 |
| 122 | Тусламжийн орлого | - | 3,217,899.5 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 227,082,020.6 | 429,060,200.6 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **222,196,639.2** | **338,167,029.6** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 222,196,639.2 | 338,167,029.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 189,623,468.5 | 307,866,171.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 108,172,884.4 | 160,317,436.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,665,281.2 | 6,356,820.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,047,654.1 | 9,530,306.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,271,596.9 | 8,287,531.1 |
| 2105 | Нормативт зардал | 7,480,698.6 | 12,705,979.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,689,111.6 | 11,139,336.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,433,796.1 | 2,647,440.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 21,887,583.7 | 31,812,787.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,974,862.0 | 65,068,533.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 32,573,170.7 | 30,300,858.1 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **22,695,658.2** | **176,354,955.3** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **23,722,747.2** | **116,012,982.3** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 23,722,747.2 | 116,012,982.3 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 23,722,747.2 | 116,012,982.3 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(23,722,747.2)** | **(116,012,982.3)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **(1,027,089.1)** | **60,341,973.0** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,558,352.9 | 531,263.8 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 531,263.8 | 60,873,236.8 |

## 2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **547,493,099.1** | **-** | **547,493,099.1** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 12,553,772.9 | - | 12,553,772.9 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 560,046,872.0 | - | 560,046,872.0 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (1,767,059.4) | - | (1,767,059.4) |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 1,169,714.4 | - | 1,169,714.4 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 4,693,679.9 | - | 4,693,679.9 |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **564,143,206.9** | **-** | **564,143,206.9** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,181,504.4 | - | 1,181,504.4 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 565,324,711.3 | - | 565,324,711.3 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (11,746.7) | - | (11,746.7) |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 253.4 | - | 253.4 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 156,864,142.5 | - | 156,864,142.5 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **722,177,360.5** | - | **722,177,360.5** |

### 2.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **363,931,818,700.00** | **360,760,937,664.71** | **3,170,881,035.29** | **99.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **255,364,415,400.00** | **252,676,220,250.61** | **2,688,195,149.39** | **98.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **241,969,860,900.00** | **239,487,420,777.33** | **2,482,440,122.67** | **99.0** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **159,376,424,700.00** | **157,969,656,677.11** | **1,406,768,022.89** | **99.1** |
| 210101 | Үндсэн цалин | 95,160,435,200.00 | 94,251,488,744.31 | 908,946,455.69 | 99.0 |
| 210102 | Нэмэгдэл | 54,885,435,000.00 | 53,761,262,451.64 | 1,124,172,548.36 | 98.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,812,227,500.00 | 4,376,572,133.29 | (564,344,633.29) | 114.8 |
| 210104 | Урамшуулал | 5,518,327,000.00 | 5,570,370,008.11 | (52,043,008.11) | 100.9 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 9,963,339.76 | (9,963,339.76) | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **6,324,058,100.00** | **6,097,710,722.47** | **226,347,377.53** | **96.4** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,364,682,300.00 | 2,313,764,459.02 | 50,917,840.98 | 97.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 296,897,100.00 | 274,302,189.20 | 22,594,910.80 | 92.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 149,886,700.00 | 146,790,221.28 | 3,096,478.72 | 97.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 150,931,300.00 | 132,768,635.07 | 18,162,664.93 | 88.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,361,660,700.00 | 3,230,085,217.90 | 131,575,482.10 | 96.1 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **9,855,669,100.00** | **9,276,313,986.89** | **579,355,113.11** | **94.1** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,270,863,800.00 | 1,970,343,534.31 | 300,520,265.69 | 86.8 |
| 210302 | Түлш, халаалт | 6,165,369,200.00 | 6,008,661,671.96 | 156,707,528.04 | 97.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 591,946,700.00 | 499,143,858.08 | 92,802,841.92 | 84.3 |
| 210304 | Байрны түрээс | 827,489,400.00 | 798,164,922.54 | 29,324,477.46 | 96.5 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,036,778,400.00** | **6,026,868,991.43** | **9,909,408.57** | **99.8** |
| 210401 | Бичиг хэрэг | 372,976,500.00 | 374,769,640.70 | (1,793,140.70) | 100.5 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,575,545,700.00 | 4,572,796,309.80 | 2,749,390.20 | 99.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 295,543,300.00 | 296,532,523.08 | (989,223.08) | 100.3 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,385,000.00 | 2,385,000.00 | - | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон | 54,499,300.00 | 52,262,521.75 | 2,236,778.25 | 95.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | мэрэгчдийн устгал, ариутгал | | | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 735,828,600.00 | 728,122,996.10 | 7,705,603.90 | 99.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **13,136,469,900.00** | **13,127,276,076.58** | **9,193,823.42** | **99.9** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,468,769,000.00 | 1,468,215,894.66 | 553,105.34 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 5,235,777,500.00 | 5,227,228,086.92 | 8,549,413.08 | 99.8 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,431,923,400.00 | 6,431,832,095.00 | 91,305.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **11,771,660,700.00** | **11,702,351,877.26** | **69,308,822.74** | **99.4** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,109,981,300.00 | 3,111,946,730.87 | (1,965,430.87) | 100.1 |
| 210602 | Тавилга | 65,000,000.00 | 64,996,000.00 | 4,000.00 | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 226,984,800.00 | 201,014,338.00 | 25,970,462.00 | 88.6 |
| 210604 | Урсгал засвар | 8,369,694,600.00 | 8,324,394,808.39 | 45,299,791.61 | 99.5 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,181,523,800.00** | **1,165,151,843.50** | 16,371,956.50 | 98.6 |
| 210701 | Гадаад албан томилолт | 50,000,000.00 | 49,995,251.50 | 4,748.50 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 988,993,800.00 | 972,859,644.00 | 16,134,156.00 | 98.4 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 142,530,000.00 | 142,296,948.00 | 233,052.00 | 99.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **33,198,107,900.00** | **33,038,040,619.66** | **160,067,280.34** | **99.5** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 23,206,426,700.00 | 23,109,672,367.66 | 96,754,332.34 | 99.6 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 33,571,300.00 | 24,520,499.20 | 9,050,800.80 | 73.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,957,893,000.00 | 5,955,606,322.72 | 2,286,677.28 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 128,737,800.00 | 111,054,292.22 | 17,683,507.78 | 86.3 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 25,426,600.00 | 23,048,960.00 | 2,377,640.00 | 90.6 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,392,080,400.00 | 3,390,852,535.34 | 1,227,864.66 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 286,907,500.00 | 257,952,962.52 | 28,954,537.48 | 89.9 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 650,000.00 | 75,100.00 | 574,900.00 | 11.6 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 166,414,600.00 | 165,257,580.00 | 1,157,020.00 | 99.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,089,168,300.00** | **1,084,049,982.43** | **5,118,317.57** | **99.5** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 420,402,900.00 | 417,132,843.43 | 3,270,056.57 | 99.2 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 668,765,400.00 | 666,917,139.00 | 1,848,261.00 | 99.7 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **13,394,554,500.00** | **13,188,799,473.28** | 205,755,026.72 | 98.5 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **409,733,200.00** | **408,808,476.57** | 924,723.43 | 99.8 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 409,733,200.00 | 408,808,476.57 | 924,723.43 | 99.8 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **12,984,821,300.00** | **12,779,990,996.71** | 204,830,303.29 | 98.4 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 54,388,300.00 | 54,347,900.00 | 40,400.00 | 99.9 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 4,500,000.00 | 4,400,000.00 | 100,000.00 | 97.8 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 8,596,693,600.00 | 8,404,408,684.71 | 192,284,915.29 | 97.8 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 3,530,890,000.00 | 3,524,402,483.00 | 6,487,517.00 | 99.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 798,349,400.00 | 792,431,929.00 | 5,917,471.00 | 99.3 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **108,567,403,300.00** | **108,084,717,414.10** | 482,685,885.90 | 99.6 |
| 220001 | Барилга байгууламж | 69,109,661,100.00 | 69,106,674,106.00 | 2,986,994.00 | 100.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 20,578,000,000.00 | 20,098,838,470.00 | 479,161,530.00 | 97.7 |
| 223001 | Бусад хөрөнгө | 8,500,000,000.00 | 8,500,000,000.00 | - | 100.0 |
| 224001 | Стратегийн нөөц хөрөнгө | 10,379,742,200.00 | 10,379,204,838.10 | 537,361.90 | 100.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **363,931,818,700.00** | **360,760,959,414.71** | **3,170,859,285.29** | **99.1** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **347,832,788,600.00** | **341,775,295,381.36** | 6,057,493,218.64 | 98.3 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 347,832,788,600.00 | 341,775,295,381.36 | 6,057,493,218.64 | 98.3 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **16,099,030,100.00** | **19,177,481,850.35** | (3,078,451,750.35) | 119.1 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 16,087,616,100.00 | 19,158,065,795.35 | (3,070,449,695.35) | 119.1 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,414,000.00 | 19,416,055.00 | (8,002,055.00) | 170.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Тохируулгын орлого, зарлагын зөрүү | - | (191,817,817.00) | 191,817,817.00 | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 21,750.00 | (21,750.00) | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **1,758.00** | **1,682.00** | 76 | 95.7 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **26** | **26** | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 26 | 26 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **866** | **828** | 38 | 95.6 |
| 620001 | Удирдах ажилтан | 55 | 47 | 8 | 85.5 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 677 | 664 | 13 | 98.1 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 134 | 117 | 17 | 87.3 |

### 2.6 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **87,745,676,849.49** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **84,424,062,990.49** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | **75,082,908,068.53** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **-** | **2,347,779,684.58** |
| 210101 | Үндсэн цалин | - | 298,430,967.24 |
| 210102 | Нэмэгдэл | - | 1,080,029,614.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 2,109,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 144,626,399.27 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 822,583,704.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **-** | **259,110,098.87** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 203,909,824.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 6,780,804.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 4,261,108.33 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 2,988,207.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 41,170,154.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **-** | **255,581,507.43** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 20,196,359.52 |
| 210302 | Түлш, халаалт | - | 213,094,281.72 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 14,428,466.19 |
| 210304 | Байрны түрээс | - | 7,862,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **-** | **2,387,978,411.20** |
| 210401 | Бичиг хэрэг | - | 160,440,308.40 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 1,817,946,937.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 12,967,940.80 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 45,017,750.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 18,775,734.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 332,829,741.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | **1,899,653,491.88** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 142,611,730.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 632,186,494.88 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,124,855,267.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **-** | **3,227,785,849.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 953,837,835.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210602 | Тавилга | - | 683,563,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 106,811,800.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,483,572,314.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **1,482,386,049.40** |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 122,644,475.40 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 1,337,586,552.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | 22,155,022.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **-** | **1,629,604,055.05** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,593,120,661.05 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 960,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 3,171,525.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 359,109.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 31,204,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 113,760.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 675,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **-** | **61,593,028,921.12** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 61,347,248,757.12 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 245,780,164.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **9,341,154,921.96** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **-** | **630,477.28** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 630,477.28 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **2,873,230,769.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 237,031,159.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 2,636,199,610.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **6,467,293,675.68** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 6,465,611,004.35 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,682,671.33 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **3,321,613,859.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **-** | **3,321,613,859.00** |
| 220001 | Барилга байгууламж | - | 13,700,200.00 |
| 221001 | Их засвар | - | 1,197,729,769.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 16,850,000.00 |
| 224001 | Стратегийн нөөц хөрөнгө | - | 40,948,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 2,052,385,090.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **87,745,676,849.49** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **87,745,676,849.49** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 6,680,288,471.44 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 52,810,545,908.90 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 6,030,976,863.66 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 22,223,865,605.49 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **-** | **-** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 117,353.9 сая төгрөгийн 135 алдаа[1] илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 141,347.6 сая төгрөгийн зөрчил илэрч, 95.5 сая төгрөгийн зөрчилд 39 төлбөрийн акт тогтоож, 125,584.1 сая төгрөгийн зөрчилд 103 албан шаардлага хүргүүлж, 15,668.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 108 зөвлөмжийг өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 141,347.6 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 138,489.9 сая төгрөгөөр их тул “**Хязгаарлалттай”** дүгнэлт өглөө.

### 3.1 Эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагууд

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 77 төсвийн захирагч нарын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 51 байгууллагад дүгнэлт гаргаж, 26 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” 43, “Хязгаарлалттай” 8 (*Онцгой байдлын ерөнхий газрын-ТТЗ, Стандарт, хэмжил зүйн газар-ТТЗ, Онцгой байдлын ерөнхий газрын ТШЗ, Стандарт, хэмжил зүйн газар-ТШЗ, ХАБҮЛЛ, Дорнод аймгийн Онцгой байдлын хэлтэс, Говьсүмбэр аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс, Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба*) дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 104,204.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 95.5 сая төгрөгийн зөрчилд 39 төлбөрийн акт тогтоон, 88,440.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 95 албан шаардлага хүргүүлж, 15,668.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 107 зөвлөмжийг өгсөн.

### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 37,634.0 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 490.4 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 37,143.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 албан шаардлагыг хүргүүлж, 0.03 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 60,000.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 60,000.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

#### 3.2.1 Албан шаардлага

1. Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогыг 16,099.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 25,192.1 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс 6,014.7 сая төгрөгийн давсан орлогыг зарцуулж, 3,078.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь орлогын төлөвлөлт үндэслэлгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.3.1-т “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах;”, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан хавсралт "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 1.6-д "Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа төсвийн байгууллагын үндсэн

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бодитой тооцож төсөвт тусгуулах ба хэрэв үндэслэлгүй төлөвлөгөө батлуулсан нь нотлогдвол энэ журамд заасан зарцуулах эрх олгохгүй", 3.4-т "Энэ журмын 3.1.1-д заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно", 3.4.2-т "Үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгагдахгүй орхигдуулах", 3.6-д “Энэ журмын 3.1.1-т заасан орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон 3.1.2-т заасан орлогын үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Төсвийн төлөвлөлтийг өмнөх жилүүдийн гүйцэтгэл, судалгаа тооцоонд үндэслэн бодитой төлөвлөж байх, нэмэлт орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийг харгалзан нэмэгдүүлж төлөвлөгөөгүй, бодитой тооцож төсөвт тусгуулаагүй зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгаагүй, тайлант онд Онцгой тусгай хувцас, хэрэгслийн туршилт үйлдвэрлэлийн төв 121 дүгээр анги 2,446.6 сая төгрөгийн, Замын үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба 55.7 сая төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.", 44 дүгээр зүйлийн 44.4-т "Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4-т "Энэ журмын 3.1.1-д заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно", 3.4.2-т "Үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгагдахгүй орхигдуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгаагүй зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

3. Стандарт, хэмжил зүйн байгууллагуудад Сангийн сайдын тушаалаар зарцуулах эрх олгосон 5,513.9 сая төгрөгийн давсан орлогоос 4,478.8 сая төгрөгийн орлого нь Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар тушаалаар Стандарт, хэмжил зүйн салбараас үзүүлж байгаа ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор нэмэгдсэн, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогод хамаарахааргүй байхад орлогод тооцон зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалын хавсралт "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 1.6-д "Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бодитой тооцож төсөвт тусгуулах ба хэрэв үндэслэлгүй төлөвлөгөө батлуулсан нь нотлогдвол энэ журамд заасан зарцуулах эрх олгохгүй", 3.3-т "Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогод дараах орлогыг хамааруулахгүй", 3.3.3-т "төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний үнэ, тарифт орсон өөрчлөлттэй холбоотойгоор нэмэгдсэн төлөвлөгөөт орлого" гэж заасантай нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний үнэ, тарифт орсон өөрчлөлттэй холбоотойгоор нэмэгдсэн төлөвлөгөөт орлогыг нэмэлт орлогод

тооцож зарцуулах эрх олгосон зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

4. Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд тайлант онд гэрэл цахилгааны зардлаас 1.6 сая төгрөгийн, шуудан, холбоо, интернэтийн төлбөрийн зардлаас 0.5 сая төгрөгийн, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 23.4 сая төгрөгийн, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 0.6 сая төгрөгийн, зочин төлөөлөгч хүлээн авах зардлаас 0.1 сая төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас 47.6 сая төгрөгийн, улсын мэдээллийн маягт бэлтгэх зардлаас 0.9 сая төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлаас 123.1 сая төгрөгийн, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 10.2 сая төгрөгийн, нийт 208.0 сая төгрөгийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

